

## ХОЛБОО БАРИХ:

**Утас:** (976) 7511-4444  
**И-мэйл:** mongolbasalt@rockwool.mn  
**Вэб:** basaltwool.mn

Улаанбаатар хот,  
2019.08.01

**Хаяг:** Фланминго Тауэр,  
Сүхбаатар дүүрэг, 1-р  
хороо, Улаанбаатар хот,  
14210, Монгол Улс

### Хэвлэлийн мэдээ

## "МОНГОЛ БАЗАЛТ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Монгол Базальт" /MSE:MBW/ нь 2019 оны 6-р сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон санхүү, бизнесийн үйл ажиллагааны тайлангаа танилцуулж байгаадаа баяртай байна.

### Санхүүгийн үйл ажиллагааны тухайд:

Компани тайлант хугацаанд бүтээн байгуулалт, техник технологийн шинэчлэлийн ажлуудыг эрчимтэй өрнүүлсэн хэдий ч борлуулалтын орлогоо 2018 оны 6-р сарын 30-ны хагас жилийн үзүүлэлтээс 74%-иар өсгөж 1.12 тэрбум төгрөгт хүргэлээ.

Компанийн ашигт ажиллагааны хувьд өмнөх онд алдагдалтай гарч байсан бол энэ жилийн санхүүгийн үр дүн эерэг 123.3 сая төгрөгийн ашигтай ажилласан юм.

Энэ талаар "Монгол Базальт" ХК-ийн Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл хэлэхдээ "Бидний эхний хагас жилийн үр дүн өмнөх оны үзүүлэлтүүдээс үнэмлэхүй дэвшилттэй байгаа хэдий ч бид үүнээс илүү үр дүнтэй ажиллаж чадна гэдэгт итгэлтэй байна. Иймээс бид, дараагийн хагас жилдээ илүү их зүтгэл гарган, төлөвлөгөөт бүтээн байгуулалтуудаа дуусган, гадаад зах зээлүүдрүү нэвтрэх үйл ажиллагаандаа эрчимтэй орж ажиллах зорилго тавьсан байна"

### Тайлантай танилцах

Эрхэм хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагч та бүхэн 2019 оны эхний хагас жилийн тайланг манай компанийн [www.basaltwool.mn](http://www.basaltwool.mn) болон Монголын Хөрөнгийн Биржийн [www.mse.mn](http://www.mse.mn) цахим хуудаснаас танилцана уу.